



АМЧАМЫН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

Стратегийн ордууд:
Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчны сорилтууд

2025 оны 7-р сар

УДИРТГАЛ

Монгол Улс уул уурхайн салбарынхаа хувьд ямар стратеги баримталж байна вэ? НҮБ-ын Худалдаа ба Хөгжлийн байгууллагын Хөрөнгө оруулалтын бодлогын үнэлгээнд 2013 онд дурдсанаар Монгол Улс байгалийн арвин баялагтай, эдийн засгийн өсөлт үзүүлэх орон хэмээн үнэлэгдсэн. Гэвч уул уурхайгаас бий болох орлогыг үр дүнтэй ашиглан, тогтвортой хөгжилд чиглүүлэх нь туйлын чухал гэдгийг ч онцолж байв. Тодорхой хөгжлийн зорилготой, иж бүрэн хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлохоос гадна хууль, эрх зүйн шинэчлэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх институцын чадавхыг бэхжүүлэх шаардлагатайг тухайн үед дурдаж байсан. Эдгээр зөвлөмжийг өгснөөс хойш арав гаруй жил өнгөрсөн тул өнөөгийн нөхцөл байдлыг эргэн харж, дүгнэх шаардлагатай байна.

2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Хөрөнгө оруулалт, худалдааны газрын тухай 37 дугаар тогтоол батлагдаж, тус газар байгуулагдсан. Эргээд дүгнэхэд тус газар байгуулагдсанаар хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж чадсан уу? Хөрөнгө оруулалтыг татах таатай нөхцөл бүрдсэн уу? Хөрөнгө оруулагчдын эрх ашиг хамгаалагдаж, дэмжигдсэн үү? Худалдааны эргэлт нэмэгдсэн үү? Импорт орлох салбарууд хамгаалагдаж, экспорт дэмжигдсэн үү? Үүнийг үнэлэх цогц мэдээллийн сан бүрдүүлж, дүн шинжилгээ

хийсэн үү? Өнөөдрийн байдлаар тодорхой эерэг үр дүн дутмаг байна. Оюутолгойн дараа Засгийн газрын зүгээс гаргасан эерэг алхам нь Францын Орано компанитай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан явдал байв.

Эрдэнэс Монголын 100 хувь эзэмшлийн охин компани болох Мон Атом нь төрийн ураны салбар дахь оролцоог зохицуулдаг. Энэ хүрээнд хамтарсан гурван компанид хувь эзэмшдэг: МонЧех Уранд 51 хувь, Зөөвч-Овоо, Дулаан-Уул, Өмнөт ордыг хамарсан Бадрах Энержид 34 хувь, Гурвансайхан төсөлд 15 хувийг тус тус эзэмшдэг. 2023 онд Зөөвч-Овоогийн төслийн хүрээнд томоохон санаачилгууд хэрэгжиж эхэлсэн. 2025 оны 1 дүгээр сард Монгол Улсын Засгийн газар Орано компанитай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан боловч уг компанийг буюу Бадрах Энержиг чиглэсэн үг хэл, үйл хөдлөлийн дарамт ноцтой түвшинд хүрч, хөрөнгө оруулалтыг татах хүчин чармайлтад сөргөөр нөлөөлж буй билээ. Монгол Улсын Цөмийн эрчим хүчний тухай хуулиар ураны нөөцийн хэмжээнээс үл хамааран стратегийн нөөц гэж үздэг. Иймд энэхүү хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг нягт хянах шаардлагатай.

АНУ-ын Төрийн департаментын 2024 оны Хөрөнгө оруулалтын орчны тайланд дурдсанаар "Бизнесүүд бүх түвшинд ихээхэн төвөгтэй, урьдчилан таамаглах

Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам Монгол) энэхүү бодлогын баримт бичгийг Уул уурхай болон Хуулийн хороодын оролцоотойгоор боловсруулав. Бодлогын баримт бичгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн ашиглах, хэвлэн нийтлэхэд АмЧам-аас зөвшөөрөл авна.

боломжгүй зохицуулалтын дарамтад өртдөг. Яам, агентлагуудын албан тушаалтнууд хууль, дүрэм журмыг үл тоон, тэдгээрт харшилсан шийдвэрүүд гаргасаар байна. Шүүхийн шийдвэрүүд удаж гардаг бөгөөд шийдвэр гарсны дараа ч хэрэгжих хүртэл дахин их хэмжээний хугацаа зарцуулах болдог. Татварын Ерөнхий Газар зэрэг байгууллагууд маргааныг шийдвэрлэх чадваргүй, эсвэл шийдвэрлэх хүсэлгүй байгаа нь шууд бус байдлаар хувийн өмчийг хураан авах эрсдэлийг бий болгож байна. Дур зоргоороо, хэт их, албадан шинжтэй татвар ногдуулах боломжийг албан тушаалтнуудад олгодог татварын тогтолцоонд хөрөнгө оруулагчид ихээхэн санаа зовниж байна... Хууль тогтоомж батлагдсаны дараа хэрэгжилт нь тухайн хуультай нийцэж, тогтвортой хангагдах эсэхэд итгэх боломжгүй бөгөөд энэ нь Засгийн газар, УИХ-ын үйл ажиллагааг бодит бус, зөвхөн бэлгэдлийн шинжтэй болгож байна" хэмээжээ.

АНУ-Монголын хоёр талт худалдаа, хөрөнгө оруулалтын хүрээнд 2023 оны байдлаар АНУ-аас Монгол Улсад хийсэн шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 680 сая ам.долларт хүрсэн. Америкийн компаниуд онгоц, төмөр зам, уул уурхайн тоног төхөөрөмж, харилцаа холбооны салбарт идэвхтэй ажилласан байдаг. 2000-2024 оны хооронд Монголын АНУ-тай хийж буй худалдааны тэнцэл алдагдалтай байдалд шилжсэн бөгөөд үүний гол шалтгаан

нь АНУ-аас хийж буй импорт тогтмол нэмэгдсэн боловч Монголын экспорт 2012 оноос буурсан явдал юм. Монголын АНУ-руу чиглэсэн экспорт маш бага, олон жилийн турш өөрчлөгдөөгүй байгаа нь экспортын төрөлжилт хангалтгүй байгааг харуулж байна. АмЧам Монгол саяхан "АНУ-Монголын худалдаа, эдийн засгийн харилцааны товч эмхэтгэл"-д энэ талаар тайлбарласан.

Хууль дээдлэх зарчим сэргээгдэж, хөрөнгө оруулагчид болон бизнес эрхлэгчдийн эрх ашиг хангалттай хамгаалагдахгүй бол Монгол Улс хөрөнгө оруулалт хийхэд таагүй орчин хэвээр байх болно. Үндсэндээ Монгол Улсад уул уурхайн салбартаа баримтлах тодорхой стратеги дутмаг байна. Хууль эрх зүйн болон зохицуулалтын тогтворгүй байдал, төрийн хэт их оролцоо, Баялгийн сангийн тохиромжгүй менежмент, хөрөнгө оруулагчдын эрхийг хангалттай хамгаалж чадахгүй байдал, маргаан шийдвэрлэх шударга бус тогтолцоо, таагүй хөрөнгө оруулалтын орчин, бодлого ба түүний хэрэгжилт хоорондын зөрүү зэрэг асуудлууд энэ улсын өмнө тулгарч байна. Монгол Улсыг сорилттой нөхцөл байдлаас гаргах зорилгоор эдийн засгийн тулгуур болсон хувийн хэвшлийн туршлага дээр үндэслэн боловсруулсан бодлогын зөвлөмжүүдийг энэхүү баримт бичигт танилцуулна.

УРТ НЭРТЭЙ ХУУЛИАР ЭХЭЛСЭН СОРИЛТУУД

Монгол Улс өргөн уудам газар нутагтай, газрын хэвлийн баялгийн нөөцтэй боловч энэ нь хараахан бүрэн хэмжээгээр судлагдаагүй. Эрдэс баялгийн нөөц дотроо газрын ховор элементийн нөөцийг иж бүрэн үнэлсэн судалгаа өнөөг хүртэл хийгдээгүй байна.

2006 онд Монгол Улс "стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын орд" гэх ойлголтыг олон улсын тавцанд анх удаа танилцуулсан нь манай улсын эрдэс баялгийн салбарт тодорхой бодлого, стратеги тогтсон гэх ойлголтыг бий болгосон. Улмаар 2007 онд Монгол Улсын Их Хурлын 27 дугаар тогтоолоор нийт 16 ордыг стратегийн ордод хамааруулсан. Ашигт малтмалын тухай хуулийн дагуу стратегийн орд нь үндэсний аюулгүй байдал, бүс нутгийн болон улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх, эсвэл тухайн жилийн ДНБ-ий 5-аас дээш хувийг бүрдүүлдэг ордууд юм. Энэ ангиллын чухал үр дагавар нь стратегийн ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн хувьцааны 34 хувиас дээш хувийг зөвхөн Монгол Улсын Засгийн газартай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан хуулийн этгээд, эсвэл төрийн өмчит компани эзэмших боломжтой гэсэн хязгаарлалт юм.

Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн

нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль (Урт нэртэй хууль) нь уул уурхай зэрэг чухал салбаруудад хамаарах гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулж, төрийн оролцоог хуульчилсан. 2012 оны 5 дугаар сарын 17-нд батлагдсан тус хуульд зааснаар тодорхой салбаруудад гадаадын хөрөнгө оруулалт хийхэд Засгийн газар болон УИХ-ын зөвшөөрөл шаардлагатай болсон нь маргаан дагуулсан. Мөн уг хуулиар стратегийн ач холбогдолтой гэж үзсэн хөрөнгийг төр хураан авах боломжтой байв. Стратегийн ордод төрийн оролцоог заавал байлгах шаардлагын дагуу хайгуулын зардлыг хэн санхүүжүүлсэн эсэхээс шалтгаалан төр 34–50 хувийг эзэмших зохицуулалттай байлаа. Энэ хуулийг гадаадын хөрөнгө оруулалтыг сааруулсан, тодорхой бус байдал үүсгэсэн, хөрөнгө оруулагчдын итгэлийг сулруулсан гэж ихээхэн шүүмжилж байв. Иймд Урт нэртэй хуулийг 2013 оны 11 дүгээр сард цуцалсан боловч түүний сөрөг үр нөлөө удаан хугацаанд мэдрэгдсэн юм.



БАЯЛГИЙН САНГААР ҮРГЭЛЖИЛСЭН СОРИЛТУУД

2024 оны 4 дүгээр сарын 19-нд Монгол Улсын Их Хурал "Баялгийн сангийн тухай" хуулийг баталсан. Энэхүү хууль нь Баялгийн сан байгуулах, ашиглах, удирдах үйл явцыг тодорхойлсон бөгөөд үндсэн зорилго нь байгалийн баялгаас хүртэх үр өгөөжийг иргэдэд шударгаар хуваарилах явдал гэж ойлгогдож болно. Сүүлийн нэмэлт, өөрчлөлтөөр стратегийн ач холбогдол бүхий үндсэн ордууд болон эдгээртэй холбоотой үүсмэл ордуудыг ч уг зохицуулалтад хамруулсан. Өөрөөр хэлбэл, стратегийн ордтой холбоотой үүсмэл ордуудын тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төр хувь эзэмших зохицуулалт үйлчилнэ. Хэрэв стратегийн ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хувь хүн эсвэл хуулийн этгээд тухайн лицензийн эрхээ буюу газрын эзэмших, ашиглах эрх болон ашигт малтмал, цацраг идэвхт элемент, газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн эрхийг бүрэн буюу хэсэгчлэн бусдад шилжүүлбэл 30 хувийн татвар ногдуулна. Энэ нь хувьцаа, саналын эрх, оролцооны эрхийг шилжүүлэх, өөрөөр хэлбэл бэлэглэх, гэрээслэх, өвлүүлэх хэлбэртэй байж болно. Үүнтэй холбогдуулан дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд асуулт илүүтэй байгаа нь ажиглагдаж байна.

Баялгийн санг бүрэн ойлгохын тулд түүнийг бүрдүүлж буй гурван дэд санг авч үзэх шаардлагатай. Үүнд: "Ирээдүйн

өв сан", "Хуримтлалын сан", "Хөгжлийн сан" багтана. Ирээдүйн өв сан нь байгалийн баялгаас хуримтлагдсан орлогыг хойч үедээ хадгалах зорилготой. Хуримтлалын сан нь иргэдэд баялгийн өгөөжийг хуваарилах үүрэгтэй. Харин Хөгжлийн сан нь томоохон бүтээн байгуулалтын төслүүдийг санхүүжүүлэхэд чиглэнэ. Баялгийн санд төвлөрсөн хөрөнгийг Засгийн газар 14 мега төслийг хэрэгжүүлэхэд ашиглахаар төлөвлөсөн бөгөөд тэдгээрийн зарим нь Говийн бүс нутагт хэрэгжинэ. Үүнд: Гашуунсухайт-Ганцмод, Ханги-Мандал, Шивээхүрэн-Сэхэ чиглэлийн хил дамнасан төмөр зам, нүүрс-химийн болон кокс-химийн цогцолбор, газрын тос боловсруулах үйлдвэр, 450 МВт хүчин чадалтай дулааны цахилгаан станц зэрэг төсөл багтана. Ирээдүйн өв сан болон Хөгжлийн сан нь өмнө нь ч манай улсын тогтолцоонд багтаж байсан. Харин Хуримтлалын сангийн хүрээнд стратегийн ордууд дахь төрийн эзэмшлийн өгөөжөөс иргэн бүрд нэрийн данс нээж, ногдол ашиг хуваарилах тогтолцоо бий болно. Энэ нь уул уурхайн өгөөж нь олон нийтэд хүртээмжгүй байдаг гэсэн удаан хугацааны шүүмжлэлд хариулт болох зорилготой. Үүний зэрэгцээ төрийн өмчит компаниудаас иргэдэд мөнгө тараадаг практик цаашид үргэлжлэхгүй гэсэн хүлээлт буй.

Баялгийн сангийн ерөнхий ойлголтыг дотоодын томоохон хөрөнгө оруулагчид

дэмжиж, зарим нь Засгийн газартай хэлэлцээр хийх хүсэлтэйгээ чилэрхийлсэн. Стратегийн ордод хамтран хайгуул хийх үед төр ямар ч зардалгүйгээр 50 хүртэл хувийг эзэмших бол, хөрөнгө оруулагчийн санхүүжилттэй хайгуулын тохиолдолд төр 34 хувийг үнэгүй эзэмшинэ. Харин стратегийн ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөхийг хориглосон бөгөөд энэ нь нэг этгээд буюу холбоотой этгээдүүд 34 хувиас дээш хувьцаа эзэмшихээс сэргийлсэн зохицуулалт юм. Тогтвортой байдлын гэрээний хугацаа дууссан тохиолдолд төр эзэмшлийн хувь хэмжээг дахин тогтоох, улмаар өгөөжийг Баялгийн санд төвлөрүүлэх эрхтэй болно. Гэхдээ стратегийн ордын жагсаалт тогтмол биш, харин шинээр ордууд нээгдэх эсвэл одоогийн ордуудын нөөц

дуусах зэргээс шалтгаалан цаашид стратегийн ордуудын тоо өөрчлөгдөх боломжтой. Утгачилбал өнөөдрийн байдлаар энгийн орд гэж тооцогдож байгаа орд маргааш гэхэд стратегийн орд болж хувирах магадлалтай юм.



ШИНЭ УРИЛГУУД, ХУУЧИН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД

Хувийн хэвшил рүү чиглэсэн халдлага, хүч хэрэглэсэн үйлдлүүд, төрийн хүнд сурталтай зохицуулалт, олон нийтэд сөрөг мэдээлэл түгээх байдал зэрэг нь Монголын хөрөнгө оруулалтын орчны суурийг ганхуулж, хувийн хэвшилд итгэх итгэлийг ноцтойгоор алдагдуулж байна. Хувийн хэвшил ажлын байр бий болгох, шинэ санаа, инновацыг дэмжих болон улсын төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд голлох үүрэгтэй байдгийг санах хэрэгтэй. Хэн ч тоглоомын явцад дүрэм нь өөрчлөгддөг тоглоомд оролцохыг хүсэхгүйтэй адил, бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчид ч мөн адил ойлгомжтой, тогтвортой, шударга дүрэм журмын дор үйл ажиллагаа эрхлэхийг хүсдэг. Энэ тухай Америкийн Худалдааны Танхимын Удирдах зөвлөлийн гишүүн Жэймс Лиотта [ярилцлагадаа](#) онцолсон.

Монгол Улс нь олон улсын тавцанд хөрөнгө оруулагчдад ээлтэй хэмээн улсаа сурталчилдаг. Үүний хамгийн сүүлийн жишээнүүдэд Давосын Дэлхийн эдийн засгийн форум, Канадын хайгуулчид, олборлогчдын холбооны (PDAC) Торонтод болсон чуулга уулзалт, Нью-Йорк хотод болсон Монголын хөрөнгө оруулалтын форум зэргийг дурдаж болно.

"PDAC 2025" чуулга уулзалтад бэлтгэх хүрээнд АмЧам Монгол нь Аж үйлдвэр, Эрдэс баялгийн яаманд албан бичиг

хүргүүлж, хувийн хэвшлийн тулгамдсан асуудлуудыг хөндсөн. "PDAC" нь ашигт малтмалын хайгуул, олборлолтын салбарын дэлхийн тэргүүлэх арга хэмжээнүүдийн нэг бөгөөд салбарын голлох хөрөнгө оруулагчид, удирдагчдыг цуглуулдаг гэдгээрээ онцлог. Монголын төлөөлөгчдийг уг арга хэмжээнд үр дүнтэй оролцуулахын тулд АмЧам дараах асуудлуудыг онцгойлон анхаарах шаардлагатайг тэмдэглэсэн. Үүнд:

- Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбоотойгоор эрх зүйн орчныг тодорхой болгох, ахиц дэвшил гаргах шаардлага;
- 2024 оны 4 дүгээр сараас хойш зогсоод буй хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг сэргээх хэрэгцээ;
- "PDAC" чуулга уулзалтын үеэр хувийн хэвшлийн амжилтын түүхүүдийг онцлон танилцуулахын ач холбогдол;
- Татварын маргааны шийдвэрлэлт, цаашид үүсэх маргаанаас сэргийлэх стратегийн талаарх мэдээлэл;
- Гадаадын хөрөнгө оруулагчидтай төрийн хамтын ажиллагаа шаардлагатай байгаа тухай асуудлууд багтсан.

Олон жилийн турш хөрөнгө оруулагчдад амлалтууд өгч ирсэн ч

маргаан нь шүүхийн болон арбитрын шатанд хүрэхээс өмнө шийдвэрлэгдэх, маргаан үүсгэхээс сэргийлэх тогтолцоо одоогоор алга. Маргаан шийдвэрлэх чиглэлээр үүрэг өгөгдөх боловч Засгийн газрын тогтоолууд хангалттай хэрэгждэггүй хэвээр. Маргаан шийдвэрлэх механизмын үр дүн хангалтгүй байна. Татварын Ерөнхий Газар маргаан бүрэн шийдэгдээгүй байхад аж ахуйн нэгжийн банкны дансыг царцаах заналхийлэл хийдэг нь компанийн үйл ажиллагааг доголдуулах, дампууралд хүргэх эрсдэл үүсгэдэг.

Жишээлбэл Татварын Ерөнхий Хуулийг хэрэгжүүлэх явцад хуулийн 47 дугаар зүйлийн 47.3-т заасан заалтыг мөрдөхгүй байгаа нь нэг асуудал юм. Уг заалтаар нөхөн ногдуулалтын актад гомдол гаргахдаа уг актаар нөхөн ногдуулсан татварын хүлээн зөвшөөрөөгүй дүнгийн 10 хувийг урьдчилж төлөх ба уг төлөх дүн нь 100 сая төгрөгөөс хэтрэхгүй байна гэж заасан байдаг. Гэвч бодит байдал дээр нөхөн ногдуулалтын актын нийт дүнг төлөхийг шаарддаг нь аж ахуйн нэгжид санхүүгийн хэт их дарамт үзүүлж, үйл ажиллагаагаа зогсоох, дампуурах эрсдэлд хүргэдэг. 2023 оны мэдээллийг дүгнэхэд нийт татварын маргааны ердөө 10 хувь нь татвар төлөгчийн талд шийдэгдсэн нь маргаан шийдвэрлэх тогтолцоо хэт нэг талыг баримталдаг бөгөөд Маргаан Таслах Зөвлөлийн хараат бус байдал хангалтгүй байгааг харуулж байна.

Олон улсын чуулга уулзалтын индэр дээр өгсөн амлалтууд болон тэдгээрийн дараа хийгдэж буй бодит алхмууд зөрүүтэй байгаа нь хөрөнгө оруулалт татахад ноцтой саад учруулах эрсдэлтэй. Хөрөнгө оруулагчдыг урьсан урилга, ирсний дараах дэмжлэг хооронд уялдаа байх ёстой. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалж, хариуцлагатай бизнесийн зарчмыг харилцан баримтлах нь нэн чухал.

Америкийн Худалдааны Танхимын энэ оны 5 дугаар сарын уулзалтын үеэр АНУ-ын Элчин сайд Ричард Л. Буанган [илтгэлдээ](#) маш тодорхой хэлсэн:

"Ойроос харахаар яам, агентлагийн албан тушаалтнууд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиудыг байнга, дур зоргоороо зөрчдөг нь шат дамжлага бүрд урьдчилан таамаглах аргагүй зохицуулалтын дарамт ихээхэн байгааг харуулдаг. Маргаан шийдвэрлэх, шийдвэр хэрэгжүүлэх явц удаан хугацаагаар хойшлогдож, ингэхдээ ихэвчлэн нууцын халхавчны ард байдаг нь дотоодын ч, гадаадын ч хөрөнгө оруулагчдад улам их саад бэрхшээл учруулдаг. Ялангуяа дур зоргоороо, хэт их, албадан шинжтэй татвар ногдуулах боломжийг албан тушаалтнуудад олгодог татварын тогтолцоонд хөрөнгө оруулагчид ихээхэн санаа зовниж байна. Хувийн хэвшлийн компаниудаас илүүтэйгээр төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг төр чухалчлан үздэг гэсэн ойлголт нь одоогийн хөрөнгө оруулагчид бизнесээ өргөжүүлэх, шинэ хөрөнгө оруулагчид орж ирэхэд саад болж байна. Эцэст нь, стратегийн ач холбогдол бүхий уул уурхайн компанийн хөрөнгийн 34-өөс доошгүй хувийг ямар ч нөхөн олговоргүйгээр төр хураан авч, Монгол Улсын баялгийн санг босгоход чиглэсэн 2024 оны багц хууль байна. Хөрөнгө хураах хаалгыг нэг талбарт нээсэн Засгийн газар бусад талбарт ч ийм үйлдэл хийх вий гэсэн болгоомжлолыг гадаад, дотоодын бизнесийнхэн, тэр дундаа АмЧам илэрхийлж байна. Бизнесийн хүрээнийхэн эдгээр асуудлыг Засгийн газар болон хууль тогтоох байгууллагын удирдлагуудад уламжилж, эдгээр хуульд тусгагдсан хөрөнгө хураах заалтуудыг эргэн харахыг хүсжээ."

04

ЗАЛРУУЛАХ ОРОЛДЛОГУУД

2025 оны 3 дугаар сарын 28-нд УИХ-ын гишүүн Болдын Уянга төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод хаягласан албан бичигтээ "Үндэсний баялгийн сан амжилттай хэрэгжсэнээр нийт нутгаар эрэл, хайгуул гэлтгүй геологийн суурь судалгааны ажлуудыг явуулахад хүртэл ард иргэдийн эсэргүүцэлтэй тулгарах асуудал арилж, уул уурхайн салбарын үр өгөөжийг иргэд дэмжиж ойлгоно. Гэсэн хэдий ч Хуримтлалын сан нь зөвхөн тодорхой тооны "стратегийн ашигт малтмалын орд" гэх тодотголтой ордоос бүрдүүлэх орлогоор хязгаарлагдаж буй нь уул уурхайн салбарт хөрөнгө оруулсан хувь хүн, аж ахуйн нэгжид хөрөнгө оруулалтынх нь үр дүнгээр бий болсон ордыг ирээдүйд "стратегийн" хэмээн ангилж, төр-олон нийтийн өмчид авч болзошгүй гэсэн болгоомжлол, эрсдэлийг үүсгэж байна" хэмээжээ.

Энэхүү болгоомжлолыг бууруулах үүднээс Болдын Уянга гишүүн дараах саналуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бий болсон "стратегийн орд" гэх ойлголт, нэр томъёог засварлах;
- Уул уурхайн шинэ төслүүдийн хувьд Хуримтлалын санд орж ирэх тогтмол, тодорхой, ил тод хураамжийг

хуульчилж тогтоох;

- Төрийн оролцоо биш, татварын бодлогоор хуримтлал бий болгох нөхцөлийг бүрдүүлэх;

Жишээлбэл борлуулалтын орлогын 1-3 хувьд татвар ногдуулах боломжтой байх талаар тусгах хувилбаруудыг дурдсан. Гэхдээ энэ саналууд хөрөнгө оруулагчдын болгоомжлолыг багасгаж, сэтгэл зүйн хувьд эерэг өөрчлөлт авчрах эсэх нь хараахан тодорхойгүй байна.

2025 оны 4 дүгээр сарын 25-нд тухайн үеийн Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ¹ Баялгийн сангийн эхний жилийн хэрэгжилтийн албан ёсны тайланг УИХ-д танилцуулсан. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд нийт 495.6 тэрбум төгрөгийг иргэдийн нэрийн хуримтлалын дансанд төвлөрүүлээд байгааг дурдаад энэхүү тогтолцооны эцсийн зорилго нь баялгийн өгөөжийг "33-33-33" зарчмаар хуваарилах явдал юм хэмээн онцолсон. Үүнд:

- **33 хувь** – хойч үед,
- **33 хувь** – иргэдийн хуримтлалын дансанд,
- **33 хувь** – улсын болон бүсчилсэн хөгжилд хуваарилагдана.

Энэ үеэр УИХ-ын гишүүд Хуримтлалын сан, төрийн сангуудын удирдлага, менежмент, ил тод байдал хангалтгүй байгаа талаар санаа зовниж буйгаа

¹ Энэхүү баримт бичгийг бэлтгэж байх үед Ерөнхий сайд асан Л.Оюун-Эрдэнэ нь итгэл үзүүлэх санал хураалтад хангалттай дэмжлэг авч чадаагүй тул албан тушаалаасаа огцорсон болно.

илэрхийлсэн. Урт хугацааны хөгжил, тогтворжуулалтын зорилгод бус, төсвийн алдагдлыг нөхөх богино хугацааны шийдэл болгон ашиглаж буй хандлага нэмэгдэж байгааг гишүүд шүүмжилсэн. Мөн хөрөнгө оруулалтын сангийн менежмент хийх чадамжтай мэргэшсэн баг, тогтолцоо дутмаг байгааг тэмдэглэсэн.

УИХ-ын гишүүдийн ажигласнаар сангаас гарч буй зарцуулалтууд нь улс төрийн нөлөөлөлд автсан шинжтэй байдаг нь Баялгийн сангийн зорилго, нэр хүндэд сөргөөр нөлөөлдөг. Үүнтэй холбогдуулан гишүүд Баялгийн сангийн ил тод байдал, гүйцэтгэл, урт хугацааны удирдлагыг сайжруулахын тулд олон улсын хараат бус хяналтын тогтолцоо бүрдүүлэх талаар анхаарах шаардлагатай гэж үзсэн.

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудын талаарх шинэ шийдвэрүүд ч хүлээгдэж байна. 2025 оны 5 дугаар сарын 8-нд УИХ-ын даргын захирамжаар ажлын хэсэг

байгуулагдан, УИХ-ын 2007 оны 27 дугаар тогтоолоор стратегийн ач холбогдолтойд хамааруулсан ордуудын хэрэгжилт, бодит байдлыг шалгаж, санал, дүгнэлт гаргах үүрэг авсан. Уг ажлын хэсгийн урьдчилсан дүгнэлт нь энэ оны намрын чуулганы үеэр танилцуулагдахаар төлөвлөгдсөн байна.

АмЧам Монгол нь дараах асуудлыг анхааруулсаар ирсэн билээ. Үүнд:

- Төрийн хэт их оролцоо, хөрөнгө хураах оролдлогууд нь гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг зогсоож, итгэлцэлд сөргөөр нөлөөлж буйг;
- Татварын реформ зайлшгүй шаардлагатайг тус тус онцолсон.



05

ТӨСТЭЙ ЗАМНАЛ

Сахарын цөлийн өмнөд хэсэгт орших Бүгд Найрамдах Замби Улс нь байгалийн баялгийн нөөц элбэгтэй, хөгжиж буй орнуудын нэг боловч гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, тогтоон барих тал дээр бэрхшээлүүдтэй тулгарсаар байна. Зэсийн олборлолтоор дэлхийд долоодугаарт бичигддэг ч хууль эрх зүйн орчин, бодлогын тогтворгүй байдал, төрийн хэт их оролцоо, зохицуулалтын тодорхой бус байдал зэрэг нь тус улсын эдийн засгийн боломжид сөргөөр нөлөөлсөөр ирсэн.

Замби улс нь чухал ашигт малтмалын төрийн эзэмшлийг нэмэгдүүлэх бодлого баримталж байсан түүхтэй. Тухайлбал, 2008 онд батлагдсан "Уул уурхай, эрдэс баялгийн хөгжлийн тухай хууль"-аар төрийн нөлөө, орлогыг нэмэгдүүлэх зорилгоор ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг (АМНАТ-ийг) 0.6 хувиас 3.0 хувь болгон нэмэгдүүлж, уул уурхайн төсөлд дотоодын түншлэл



зайлшгүй байхыг шаардаж, шинээр олж илрүүлсэн болон хараахан илрээгүй ордуудыг төр өөрийн хэрэгцээнд авах эрхийг баталгаажуулсан юм. Уг хууль нь улсын орлогыг нэмэгдүүлэх зорилготой байсан ч уул уурхайн хөрөнгө оруулалтын өгөөжийг бууруулж, хөрөнгө оруулагчдыг үргээх сөрөг үр дагавартай байв. Үүн дээр 2008 оны дэлхийн санхүүгийн хямрал нэмэгдэж, металлын үнэ унаснаар хөрөнгө оруулагчдын итгэл эрс буурсан. Монголын баялгийн сангийн жишээн адилаар Замби улс энэ онд өөрийн **Үндэсний баялгийн санг** эхлүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд ил тод байдлыг хангах, татварын урамшуулал үзүүлэх, олон улсын түншүүдтэй хамтран уурхай болон баяжуулах үйлдвэрүүдийг хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх замаар хөрөнгө оруулалтыг татах зорилготой. Гэсэн хэдий ч Замбийн санхүүгийн эмзэг байдал, нийгэм, эдийн засгийн амин чухал асуудлуудыг шийдвэрлэх хэрэгцээг харгалзан Баялгийн санг түр хойшлуулах шаардлагатай гэсэн байр суурь ч яригдаж байна.

Замби нь төрийн хяналтад авах ба зах зээлд чөлөөтэй орхих бодлогын хооронд тогтмол хэлбэлздэг улс. Уул уурхайн салбарын татварын бодлого байнга өөрчлөгдөж, хууль эрх зүйн орчин тодорхой бус байгаагаас гадаадын хөрөнгө оруулагчдын итгэл буурсан. Ерөнхийлөгч Хичилема хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахын төлөө ажиллаж, 2022 онд АМНАТ-ийг хасалт хийх боломжтой болгох **шинэ бодлого** нэвтрүүлж, хууль дээдлэх зарчмыг баримтлах амлалт өгсөн. Уул уурхайн хууль, тогтоомжийг тогтмол өөрчлөхөөс зайлсхийснээр хөрөнгө оруулагчдад зохицуулалтын тогтвортой байдлыг нотлон харуулах зорилготой. Харин 2013 онд Монгол Улсад Урт нэртэй хуулийг хүчингүй болгосон боловч татварын хууль хэрэгжилтийн тогтворгүй байдал, маргаан шийдвэрлэх сул механизм зэрэг асуудлууд нь гадаадын хөрөнгө оруулагчдыг татахад хүндрэл учруулсаар байна.

Замби ба Монгол улсууд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, уул

уурхайн салбарыг хамтын ажиллагаагаар урагшлуулах стратегийг хэрэгжүүлэхээр хичээж байгаа ч хууль эрх зүйн тогтвортой байдал, хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалах тогтолцоо дутмаг бол байгалийн баялаг ганцаар хангалтгүй гэдгийн тод жишээ. Аль аль нь бодлогын шинэчлэлийг хэрэгжүүлснээр дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг илүү ихээр татах боломжтой. Үүнд:

- Хөрөнгө оруулагчийн өмчийн эрхийг урт хугацаанд хамгаалсан хууль тогтоомж батлах;
- Татварын бодлогоор урамшуулах тогтолцоог нэмэгдүүлэх;
- Баялгийн сангуудыг хараат бус байгууллагаар хянуулах, улс төрөөс тусгаарлах зэргийг дурдаж болно.

Эдгээр шинэчлэл нь итгэлцэл, тогтвортой байдлыг хангаж, хөрөнгө оруулагч болон Засгийн газрын хооронд харилцан итгэх үндэс суурь тавьж чадна. Цаашид Монгол шиг хөгжиж буй орнууд чөлөөт зах зээлийн зарчим ба төрийн оролцооны тэнцвэрийг зөв олох нь байгалийн баялгаасаа хамгийн их үр өгөөж хүртэх үндсэн нөхцөл болно.

ДҮГНЭЛТ

Энэхүү бодлогын баримт бичгийг бэлтгэхдээ АмЧам Монгол нь стратегийн ордуудтай холбогдсон асуудлуудыг дэлгэрүүлэн судалсан. Монгол Улсын зохицуулалтын орчин нь нарийн төвөгтэй төдийгүй бизнес эрхлэхэд ихээхэн санхүүгийн дарамт учруулдаг. Стратегийн ордуудыг тодорхой тооны ордуудаар тодорхойлсноор анхны зорилгодоо нийцэхгүй, сөрөг үр дагавар авчрах магадлалтай. Томоохон хөрөнгө оруулалтыг хамгаалах, бизнесийн эрсдэлийг бууруулах бодлогогүй бол уул уурхайн салбар аажмаар төрийн монополд шилжиж, салбарын өсөлтөд чухал үүрэгтэй гадаадын хөрөнгө оруулалтыг хааж эхэлнэ. Хэрвээ шинэ ордуудыг гадаадын хөрөнгө оруулалтаар нээн илрүүлж чадахгүй бол уул уурхайн салбарын хөгжил зогсонги байдалд хүрнэ. Иймд Баялгийн сангийн тогтвортой байдал, амжилт нь уул уурхайн

салбарын тасралтгүй өсөлтөөс шууд хамаарна.

Дэлхийн тэргүүлэх эдийн засагтай орнууд стратегийн ач холбогдолтой эрдэс баялаг, үйлдвэрлэл, ханган нийлүүлэлтийн сүлжээгээ хамгаалахад их хэмжээний хөрөнгө оруулалт хийж байна. Харин Монгол Улсын хувьд эрдэс баялгийн стратеги тодорхой бус хэвээр. Одоогоор Монголын Засгийн газар олон стратегийн ордуудад хувь эзэмших "стратегийн ач холбогдолтой бодлого"-ыг хэрэгжүүлж байгаа ч шинэ хөрөнгө оруулалт, шинэ түнш татах ажилд дорвитой ахиц гарсангүй. Товчоор хэлбэл Монгол Улсын өмнө тулгамдаж буй асуудлууд нь:

- Хууль эрх зүй, зохицуулалтын тогтворгүй байдал,
- Төрийн хэт их оролцоо ба хөрөнгө



хураах оролдлого,

- Баялгийн сангийн оновчгүй удирдлага,
- Хөрөнгө оруулагчийн эрхийг хангалттай хамгаалдаггүй тогтолцоо,
- Шударга бус маргаан шийдвэрлэлтийн механизм,
- Таагүй хөрөнгө оруулалтын орчин,
- Хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого, хэрэгжилтийн зөрүү зэргээр тодорхойлогдож байна.

Баялгийн сангийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн нь өмнө дурдсан гадаадын хөрөнгө оруулалттай компани болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдтэй хамтарсан төрийн эзэмшлийн хувь хэмжээг үнэлэх асуудлыг хурцаар тавьж, тодорхойгүй байдлыг улам нэмэгдүүлж байх талтай. Хувийн хэвшил болон гадаадын хөрөнгө оруулалттай компанитай байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээний хүрээнд хэрэгжиж буй төслүүдийн ирээдүйн хувь заяа тодорхой бус байна. Мөн хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын хувьд ч ирээдүй нь бүрхэг байгаа.

УИХ-ын 27 дугаар тогтоолын хүрээнд одоогийн 16 орд дээр шинээр

тогтоогдсон нөөцийг нэмэх бодлого хэрэгжиж эхэлснээр нэмэлт асуудлуудыг бий болгож байна. Өмнө нь Монголын уул уурхайн зохицуулалт олон улсын стандартад нийцэж байгаа эсэх талаар маргаан өрнөхөд, стратегийн ордын ойлголтыг хязгаарлаж, зөвхөн 16 ордоор үлдээх санал давамгайлж байсан. Гэтэл сүүлийн үеийн стратегийн ордуудын өргөтгөсөн жагсаалт нь дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын түгшүүрийг улам нэмэгдүүлж байна. Ийнхүү төр зөвхөн өөрөө уул уурхайн үйл ажиллагаа явуулах чиг баримжаатай харагдаж байгаа нь хөрөнгө оруулалтыг бууруулж, төлөвлөсөн төслүүдийг хойшлуулж, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд саад болох сөрөг үр дагавартай. Энэ байдал нь зөвхөн гадаадын хөрөнгө оруулалт ба хувийн хэвшлийн нөлөөг бууруулаад зогсохгүй дотоодын компаниудын оролцоог ч хязгаарлах бодит эрсдэлтэй юм.



ӨСӨЛТӨД ЧИГЛЭСЭН ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖҮҮД

Хувийн хэвшилд тулгуурласан, зах зээлийн чөлөөт эдийн засаг нь Монгол Улсын урт хугацааны хөгжил дэвшлийн үндэс суурь юм. Энэ нь эдийн засаг өсөх, ажлын байр нэмэгдэх, хөрөнгө оруулалтын цар хүрээг тэлэх, мөн төрийн үйлчилгээг санхүүжүүлэх тогтвортой татварын орлогыг бүрдүүлэхэд чухал үүрэгтэй. Зах зээлийн зарчимд суурилсан улс орнуудад инновац, үр ашиг, эдийн засгийн тогтвортой байдал оршин тогтнохын зэрэгцээ аж ахуйн нэгж болон хөдөлмөр эрхлэгчдэд аль алинд нь ашигтай байдгаараа онцлог. Монголын эдийн засгийн сэргэн мандалтын он жилүүд болох 2010–2014 оны өсөлт нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, хурдацтай өсөлтийн хүчийг тод харуулсан билээ.

Харин эсрэгээрээ төрийн төлөвлөгөөт эдийн засагт тулгуурласан, төрийн өмчит аж ахуйн нэгжүүд давамгайлсан байдал нь ихэвчлэн эдийн засгийн зогсонги байдал, үр ашиггүй байдал, цаашлаад хувийн хэвшлийн боломжууд алдагдахад хүргэдэг. Төрийн оролцоо амжилттай хэрэгжсэн цөөн жишээ байдаг ч, жинхэнэ эдийн засгийн идэвхжил нь өрсөлдөөн болон хувийн хөрөнгө оруулалт цэцэглэж байх үед бий болдог. Монголын ирээдүйг баталгаатай байлгахын тулд бодлого боловсруулагчид бизнесийг дэмжих, хөрөнгө оруулалтыг татах, зах зээлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх шинэчлэлийг тэргүүлэх чиглэл болгох шаардлагатай. Ингэснээр нийт Монголчууд чанартай ажлын байр, тогтвортой эдийн засагтай болох юм.

Монгол Улсын эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг яаралтай шийдвэрлэх шаардлагатай энэ цаг үед АмЧам Монгол нь эдийн засгийг тогтворжуулж, тогтвортой өсөлтийг дэмжих, мөн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар бизнесийн орчныг сайжруулах зорилго бүхий нэн тэргүүнд анхаарал хандуулах, хэрэгжүүлэх боломжтой шийдлүүдийг санал болгож байна.

Нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай бодлогын арга хэмжээнүүд:

1

Дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд маргаан, цаашлаад салбар хоорондын болон яамд хоорондын зөрчил, ойлголтын зөрүүтэй асуудлуудыг хэлэлцэж, бодит шийдвэр гаргах, зөвшилцөлд хүрэх эрх мэдэл бүхий байгууллага тодорхой байх нь чухал. Иймд Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэдэх Эдийн засгийн хөгжлийн зөвлөл

2

Бизнесийн үйл ажиллагааны ил тод, тууштай, шударга байдлыг хангах, хувийн хэвшилд суурилсан, хөрөнгө оруулалтад ээлтэй эрх зүйн экосистемийг дэмжихүйц бодлогын тогтолцоог боловсруулах нь зүйтэй. Энэхүү бодлогын тогтолцоо нь төрийн эрх бүхий байгууллагын аудит, хяналт шалгалтыг урвуулан ашиглах явдлыг хязгаарлаж, улс

(ЭЗХЗ)-ийн үүргийг төр, хувийн хэвшлийн үр дүнтэй хэлэлцүүлгийн механизм болгон бэхжүүлж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчид болон төрийн байгууллагууд хоорондын хөрөнгө оруулалт, бизнесийн орчны чухал асуудлуудад өндөр түвшинд анхаарал хандуулж ажилладаг байхаар шинэчлэн зохион байгуулах бүрэн боломжтой хэмээн үзэж байна.

- **Хөрөнгө оруулалт, худалдааны газрын** чиг үүргийг тодорхой болгож, хөрөнгө оруулагчид Монгол Улсад нэвтрэхээс өмнө зөвлөх үүрэг бүхий, хөрөнгө оруулалтыг дэмжих нэг цэгийн үйлчилгээ үзүүлэгч эрх бүхий газар болгох, мөн яамд болон төрийн байгууллагууд хоорондын харилцаа холбоог зохицуулах замаар үл ойлголцол, гомдол үүсэхээс урьдчилан сэргийлэхэд чиглүүлэх шаардлагатай.
- **Маргаан таслах зөвлөл** (МТЗ)-ийг ялангуяа татварын асуудлаар хөрөнгө оруулагчдын тодорхой гомдлуудыг шийдвэрлэх үр дүнтэй механизм болгон өөрчлөн зохион байгуулж, хувийн хэвшил болон салбарын мэргэжилтнүүдийн оролцоог хангасан хэлбэрээр маргаан хянан шийдвэрлэх үйл явцыг хэрэгжүүлдэг болох шаардлагатай. Ингэснээр ялгаварлан гадуурхалтыг арилгаж, шударга байдлыг тогтоож, зөвлөлийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх бөгөөд Маргаан таслах зөвлөлийн ажиллах журмыг сайжруулан шинэчлэх боломж бүрдэнэ.

төрийн зорилготой, зүй бусаар мөрдөн шалгах ажиллагаа явуулахаас сэргийлж, шүүх хуралдааны үр ашиггүй байдал, өрөөсгөл байдал, хэрэгжилтийн дутагдал зэргийг шийдвэрлэхэд чиглэнэ. Мөн гаалийн үйл ажиллагааг хялбаршуулж, өрсөлдөх чадварыг хязгаарлаж буй хамгаалалтын шинжтэй татварын арга хэмжээг халан, бизнес ба хөрөнгө оруулалтын орчны урт хугацааны тогтвортой байдлыг хангах ёстой. Түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийн бодлогын шинэчлэл нь Монгол Улсыг бүс нутагтаа болон дэлхийд өрсөлдөх чадвартай орны нэг болгох нөхцөлийг бүрдүүлнэ. Хөрөнгө оруулалтыг дэмжиж, бизнесүүдийг татах чадавхыг нэмэгдүүлснээр уг бодлогын тогтолцоо нь эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгоно. АмЧам Монгол нь энэ оны эхээр гаргасан "Монгол Улсын татварын орчинд тулгамдаж буй 10 асуудал" баримт бичигтээ татвартай холбоотой бодлогын чухал зөвлөмжүүдийг санал болгосон билээ.

3

Төрийн оролцоог бууруулж, төрийн өмчит компаниудыг (ТӨК) шинэчлэн, хөрөнгө оруулалтын зохицуулалтыг тодорхой болгох шаардлагатай байна. Засгийн газар төрөл бүрийн салбарууд дахь өөрийн оролцоогоо эрс бууруулж, төрийн өмчит компаниудад бүрэн хэмжээний шинэчлэл хийх зайлшгүй хэрэгцээ үүссэн. Энэ нь илүү өрсөлдөөнт, хөрөнгө оруулалтад ээлтэй орчныг бүрдүүлэхэд тусална.

- Олон талаас нь тайлбарлаж болох ч төрийн өмчлөл ихсэх нь хөрөнгө оруулагчдад сөрөг дохио болдог төдийгүй, төрийн түншлэлгүйгээр бизнес эрхлэх

боломжгүй гэсэн утга санааг илэрхийлж, хувийн хэвшлийн оролцоог эрс бууруулдаг.

- Монгол Улс Ашигт малтмалын тухай хуулиар тодорхойлсон стратегийн орд гэх ойлголт, нэр томъёоны буруу тайлбар, хэрэглээг залруулах шаардлагатай. Стратегийн ордын ойлголтыг ашигт малтмалын борлуулалтын орлогод суурилсан татварын тогтолцоогоор орлуулах нь өрсөлдөх чадвартай бусад улс орнуудын жишигт нийцнэ.
- Төрийн өмчит компаниудын (ТӨК) үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхийн тулд тэдгээр нь хувийн хэвшлийн компаниудтай ижил тэгш нөхцөлд үйл ажиллагаа явуулах ёстой. Олон улсын жишигт нийцсэн гэрээний үндсэн дээр ТӨК-уудтай түншлэл байгуулахад ямар ч саад байхгүй.
- Стратегийн нөөц болон чухал ашигт малтмалын нөөцийг төрийн хяналтад оруулах тохиолдолд 34-50 хувийн төрийн эзэмшилтэй болгох бус, санхүүгийн урамшууллын бодлого баримтлах хэрэгтэй. Жишээлбэл Канад улсын 2022 оны Чухал ашигт малтмалын стратеги нь дэд бүтэц, судалгаа, инновац, хүний

нөөц, татварын урамшуулал, эрчим хүч болон тээврийн сүлжээнд нэвтрэх боломж зэрэгт чиглэсэн дөрвөн тэрбум ам.долларын хөтөлбөрүүдээр дэмжигдсэн. Үүний үр дүнд хөрөнгө оруулагчид ямар ч хүндрэлгүйгээр олборлосон бүтээгдэхүүнээ худалдан авагчид хүргэх боломжтой болсон.

- Баялгийн сангийн тухай хууль зэрэг хуулиудад тусгагдсан хөрөнгийг албадан хураах шинж чанартай заалтуудыг дахин хянаж үзэх шаардлагатай. Ийм заалтууд нь хөрөнгө оруулалтыг үргээж, салбарын хөгжлийг сааруулдаг, зориогүй боловч сөрөг үр дагавар дагуулж байгааг эргэж харах ёстой.
- Монгол Улс уул уурхайн салбартаа иж бүрэн хөгжлийн стратеги тодорхойлон, тус стратеги нь хууль эрх зүйн хүрээнд тусгагдаж, бүх түвшинд мэдээлэл нь ойлголтын зөрүүгүй хүрч хэрэгждэг байх учиртай. Тодорхой, урьдчилан таамаглахуйц зохицуулалтын тогтолцоог бий болгох нь хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлж, Монголын бизнесийн орчны нөхцөл байдлыг сайжруулах болно.

